



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 10/21

Бөхт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх “Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	О.Амгалантөр	(Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд	Ө.Бямбажаргал	(Иргэний төлөөлөл)
	Д.Номин-Эрдэнэ	(Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
	Б.Нарандэлгэр	(Газрын даамал)
Нарийн бичгийн дарга	Б.Амгаланжаргал	(Засаг даргын Тамгын газрын дарга)

2. Хууль тогтоомжид заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (О.Амгалантөр)-д, архивын нэгж үүсгэн баримтжуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (Б.Амгаланжаргал)-д даалгасугай.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ